

НИЙСЛЭЛИЙГ 2022 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ IV ДҮГЭЭР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Дугаар	ХБТББ-т тусгагдсан зорилт үйл ажиллагаа	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ(сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтод түвшин, үр дүн (Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (Сая.төг)	Төсвийн Гүйцэтгэл (сая.төг)		
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Гурав.Эдийн засгийн бодлого												
3.1.1	МУХТ-4.4.1 НХТЖҮЧ-4.1.1 НЗДҮАХ-3.1.1	Нийслэлийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан мэдээллийн нэгдсэн санг бий болгох	2022	НӨХГ	-	-	Нийслэлийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан мэдээллийн нэгдсэн сан байхгүй.	Ажлын даалгавар боловсруулж, мэдээллийн нэгдсэн санг бий болгох ажлыг эхлүүлсэн байна.	-	-	“Өмчийн бүртгэлийн нэгдсэн систем” хийх ажлын даалгаврын тоймыг боловсруулан системийн хөгжүүлэлт хийдэг томоохон 5 компани болох “Ай Си Ти групп”, “Интерактив”, “Ухаалаг шийдэл”, Ай Ти Зон”, Новелсофт “ компаниудад үнийн санал ирүүлэхийг хүссэн 2021.08.27-ны өдрийн 3/1017-3/1075 тоот албан бичгүүдийг хүргүүлсэн.Албан бичиг хүргүүлсэн компаниудаас “Новелсофт” ХХК болон “Ай Ти Зон” ХХК үнийн санал ирүүлэх боломжгүйгээ мэдэгдсэн бол үлдсэн компаниудаас 286 саяас 1,086.2 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн.Нийслэлийн 2022 оны төсвийн төлөвлөгөөний саналд дээрх арга хэмжээг 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр 2022-2023 он дамжин хэрэгжүүлэхээр буюу 2022 онд 500,0 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай талаар санал хүргүүлсэн боловч нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл	100%

										арга хэмжээнд тусгагдаж батлагдаагүй болно. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2022.02.15-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар байгуулагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангийн программ хангамжийн ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсэг-ийн бүрэлдэхүүнд ажиллан бодлогын даалгаврын төсөлд программ хангамжийн системд тусгах саналын өгсөн.		
3.1.2	МУХТ - 4.4.1 НХТЖҮЧ - 4.1.1 НЗДҮАХ - 3.1.1	Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат болон төрийн өмчит компанийн тоог бууруулна.	2022	НӨХГ	-	-	Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй 17 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат компани нийт 5 байна.	Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат компанийн тоог 3 болгоно.	-	-	Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудаас НИТХ-ын тогтоолоор 2 хуулийн этгээдийг татан буулгасан. Үүнд: -НИТХТ-ийн 191 дүгээр тогтоолоор "Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл"-ийг хугацаанд нь чанартай, бүрэн хэрэгжүүлэх үүрэг бүхий Дүүжин тээврийн ашиглалтын өмнөх захиргаа ОНӨТҮГ-ыг татан буулгасан. -НИТХ-ын 2022.05.30-ны өдрийн 47 дугаар тогтоол, НЗД-ын 2022 оны А/887 дугаар захирамж, НӨХГ-ын даргын хөрөнгө хүлээлгэн өгөх удирдамжийн дагуу "Үртсэн шахмал түлшний үйлдвэр" ОНӨААТҮГ-ын баланст бүртгэлтэй тоног төхөөрөмж, барилга байгууламжийг хөрөнгө хүлээлцэх актаар Булган аймгийн Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгсөн.	100%
3.1.3	МУХТ - 4.4.1 НХТЖҮЧ - 4.1.1 НЗДҮАХ - 3.1.1	Нийслэлийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ.	2022	НӨХГ	-	-	Нийслэлийн 2021 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр орон нутгийн өмчийн түрээсийн орлого 1,652.4 сая төгрөг төвлөрүүлсэн	Нийслэлийн төсөвт орон нутгийн өмчийн түрээсийн орлогоос 2,165.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.	-	-	НИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 65 дугаар тогтоолоор төрийн өмч түрээслүүлсний төлбөрийг 2 тэрбум төгрөгөөр баталсан. Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогын төлөвлөгөө жилийн эцсийн байдлаар гүйцэтгэл 1,954,097.9 мянган төгрөг төвлөрүүлсэн.	100%

3.1.5	МУХТ - 4.4.1 НЗДҮАХ – 3.1.1	Нийслэлийн өмчийн томоохон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн бодит үнэ цэнийг тогтоож, хотын хөгжлийг дэмжих, төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх. Санхүүгийн шинэ эх үүсвэрийг бий болгоно.	2022	НӨХГ	-	-	Нийслэлийн өмчийн 18 барилга байгууламжийн балансын анхны нийт үнэ 79,2 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байна.	Нийслэлийн өмчийн 18 барилга байгууламжийн зах зээлийн бодит үнэлгээг тодорхойлсон байна.	400.0	323.6	2022 онд нийслэлийн өмчид бүртгэлтэй 25 барилга байгууламжийн зах зээлийн бодит үнэлгээг тодорхойлох ажлыг зохион байгууллаа. Үүнд: -Хувьчлалын жагсаалтад орсон 15 барилга байгууламжийн зөвлөх үйлчилгээний тендерийн сонгон шалгаруулалтыг явуулж “Мөнх Оргил Трейд” ХХК шалгаран 42.5 сая төгрөгийн үнэ бүхий НӨАУГ/20221001 дугаартай гэрээг байгуулсан. -Нийслэлийн томоохон үл хөдлөх хөрөнгө болох 10 барилга байгууламжийн зөвлөх үйлчилгээний тендерийн сонгон шалгаруулалтыг явуулж, “Прайс вотер хаус күүлэрс Эдвайзори” ХХК шалгаран 281.1 сая төгрөгийн үнэ бүхий НХААГ/202204431 дугаартай 3 талт гэрээг 2022.10.21-ний өдөр байгуулсан. Үнэлгээний тайлан хүлээн авч санхүүжилтийг олгосон.	100%
Хэрэгжилтийн дундаж хувь 100%												

:

Биелэлт нэгтгэсэн:

С.Эрдэмсүвд (ЗТСХ-ийн мэргэжилтэн)